

# Зуунмод хотын Засаг даргын нэрэмжит \*ЗУУНМОДНЫ ХҮЧТЭН 2017\* АВАРГА ШАЛГАРУУЛАХ ПАУЭРЛИФТИНГИЙН ТЭМЦЭЭНИЙ ЗААВАР

2017-12-11

Зуунмод

## Нэг.Зорилго:

Пауэрлифтингийн спортоор хичээллэх хүрээг нэмэгдүүлэх, шинэ залуу тамирчдыг төрүүлэн гаргах, тамирчдын бэлтгэлжилт, ур чадварыг дээшлүүлэх, харилцан туршлага солилцуулахад оршино.

## Хоёр. Тэмцээний зохион байгуулалт, явуулах хугацаа:

Тэмцээн 2018 оны 01-р сарын 05-06нд Төв аймгийн Зуунмод сумын Аймгийн БТС-ын Газар, Хүч Тамирын Нэгдсэн Холбоо хамтран зохион байгуулна.Тэмцээнийг Аймгийн Хүч Тамирын Нэгдсэн Холбооноос томилогдсон шүүгчдийн бүрэлдэхүүн зохион байгуулж явуулна.

## Гурав. Тэмцээний техникийн зөвлөгөөн, жин үзэх:

Тэмцээн 2018 оны 01-р сарын 05-ны өдрийн 09<sup>00</sup> цагаас эхэлнэ. 2018 оны 01-р сарын 05 ны өдрийн 08,30 цагаас техникийн зөвлөгөөн жин үзнэ./бичиг баримт иргэний үнэмлэхтэй ирнэ/.Тэмцээн \*classic raw powerlifting\*/хэрэглэлгүйгээр/ явагдна. Төв аймгийн харьяалтай тамирчид оролцно.

## Дөрөв. Тэмцээний жин ангилал:

Өсвөр 16 нас хүртэл -66.+66кг , 18 нас хүртэл 74кг, +74 кг  
Охид -66.+66кг,эмэгтэй, Мастер 45 с дээш  
Залуучууд 18-24 нас 74кг, + 74 кг  
Насанд хүрэгчид 74кг, 83кг , -93 кг,  
Сонирхогч, -83 кг. +83кг

## Тав. Шагнал урамшил:

Тэмцээний төрөл тус бүрт 1, 2, 3-р байр эзэлсэн тамирчдыг алт, мөнгө, хүрэл медаль, өргөмжлөл, нийлбэр дүнгээр 1-3-р байр эзэлсэн тамирчдад алт, мөнгө, хүрэл медаль, өргөмжлөлөөр шагнаж урамшуулна.

Төв аймгийн  
Хүч Тамирын Нэгдсэн Холбоо.

БАТЛАВ.  
АЙМГИЙН БТС-ЫН ГАЗРЫН  
ДАРГА Га.ЛХАГВАСҮРЭН

АЙМГИЙН АВАРГА ШАЛГАРУУЛАХ АХМАД  
САГСАН БӨМБӨГЧДИЙНТЭМЦЭЭНИЙ ЗААВАР

2017-11-06

Зуунмод

**Нэг. Зорилго:**

Сагсан бөмбөгийн спортыг сурталчилах, хөгжүүлэх, ахмад тамирчдыг алдаршуулах, тэднээс суралцах, амжилтыг нь өсвөр үеийнхэнд танилцуулах.

**Хоёр. Тэмцээний зохион байгуулалт, хугацаа:**

Тэмцээн 2017 оны 11-р сарын 11-12-ны өдөр Аймгийн БТС-ын Газрын спорт зааланд явагдана.Тэмцээнийг 1993 оны төгсөгчид зохион байгуулна. Тоглолтын системийг техникийн зөвлөгөөн дээр шийдвэрлэнэ.

**Гурав. Багийн бүрэлдэхүүн, нас, хүний тоо:**

Тэмцээнд сум, аж ахуйн нэгж, байгууллагаас хэдэн ч баг оролцож болно.Багийн бүрэлдэхүүн 8 хүнтэй байна.

Насны ангилал:

Эрэгтэй: 40-44 нас,45-49 нас, 50-аас дээшнас

Эмэгтэй: 40-өөс дээш нас

**Дөрөв. Мандат олгох техникийн зөвлөгөөн**

Мандатыг 2017 оны 11-р сарын 11-ны өдрийн 10.00 цагт БТС-ны Газрын сургалтын танхимд олгож техникийн зөвлөгөөнийг 11.00 цагаас хийнэ.Тэмцээнд оролцох баг тамирчид:

1. Албан ёсны мэдүүлэг
2. Иргэний үнэмлэх
3. Зураг 1 %
4. Эрхийн төлбөр 5000 төгрөг

**Тав. Шагналурамшил:**

Тэмцээнд 1-р байр эзэлсэн багуудыг цом, алтан медаль, өргөмжлөл, мөнгөн шагнал, 2, 3-р байр эзэлсэн багуудыг мөнгө, хүрэлм едаль, өргөмжлөл, мөнгөн шагналаар шагнаж урамшуулна.

Жич: Тамирчид тоглолтын жигд хувцастай ар, өврийн номертой байна. Тэмцээнд оролцох тамирчид байр, хоол, унааны зардлыг өөрсдөө хариуцана.Тэмцээнд зөвхөн Төв аймгийн харьяат хүн оролцоно.

Харилцах утас: 99112554

Ерөнхий зохион байгуулагч:

Төв аймгийн 10-н жилийн I, II дунд сургуулийг 1993 онд төгсөгчид

## “АТАРЧИН-2017” СПОРТЫН НААДМЫН ЗААВАР

2017-10-05

Зуунмод

### Нэг. Зорилго:

Иргэдийг биеийн тамир спортоор хичээллэх хүрээг нэмэгдүүлэх, спортын наадмыг аймгийн хэмжээнд зохион байгуулах, тамирчдын ур чадварыг дээшлүүлэх, харилцан туршлага солилцуулахад оршино.

### Хоёр. Тэмцээний зохион байгуулалт, явуулах хугацаа:

“Атарчин-2017” спортын наадмыг 2017 оны 10-р сарын 28-29-нд Зуунмод суманд Аймгийн БТС-ын Газар, Зуунмод сумын ЗДТГазар, Спортын холбоод хамтран зохион байгуулна. Тэмцээнийг Аймгийн БТС-ын газраас томилогдсон шүүгчдийн бүрэлдэхүүн зохион байгуулж явуулна.

### Гурав. Спортын төрөл, багийн бүрэлдэхүүн:

1. Волейбол эр 7, эм 7 /нэг багт ЕБС-ийн 2 сурагч орохыг зөвшөөрнө
  2. Ширээний теннис эр 1, эм 1
  3. Шатар эр 1, эм 1 /СДМ цолтой өсвөрийн тамирчид оролцож болно/
  4. Үндэсний бөх /сумаас 2 залуу бөх /
  5. Шагайн харваа эр 7 хүнтэй баг оролцоно
- Тэмцээнд зөвхөн Төв аймгийн харьяат насанд хүрэгчид /18-аас дээш насны/ оролцоно.

### Дөрөв. Бүрдүүлэх бичиг баримт:

1. Иргэний үнэмлэх
2. 3 х 4 хэмжээтэй 1 % цээж зураг
3. Багийн мэдүүлэг
4. Эрхийн төлбөр 3000 төгрөг

### Тав. Шагнал урамшил:

Тэмцээний төрөл тус бүрд 1, 2, 3-р байр эзэлсэн баг тамирчдыг алт, мөнгө, хүрэл медаль, өргөмжлөл, мөнгөн шагналаар, байгууллагын нэгдсэн дүнгээр 1-р байр эзэлсэн сумыг цом, өргөмжлөл, спортын хэрэглэл материалаар, 2, 3-р байр эзэлсэн сумдыг өргөмжлөл, спортын хэрэглэл материалаар шагнана.

### Зургаа. Төсөв зардал:

Тэмцээнд оролцох тамирчдын байр, хоол, унааны зардлыг тухайн сум, албан байгууллага хариуцана.

### Долоо. Анхаарах зүйл:

1. 2017 оны 10-р сарын 27-ны 14.00-20.00 цагт мандат олгож, 20.00 цагаас техникийн зөвлөгөөнийг Аймгийн БТС-ын Газрын хурлын танхимд хийнэ.
2. Тэмцээнд оролцох баг тамирчид тоглолтын дүрмийн шаардлага хангасан жигд хувцас формтой байна.
3. Волейболын тэмцээнд оролцох ЕБС-ийн сурагчид заавал иргэний үнэмлэхтэй байна.
4. Мандатын материал дугуу, хоцорч ирсэн тамирчид тэмцээнд оролцох боломжгүй болохыг анхааруулж байна.
5. Тэмцээнд оролцох урьдчилсан мэдүүлэгээ 10-р сарын 25-ны дотор 99308228, 99794599 утсаар мэдэгдэнэ үү.
6. Багийн дүнг бүх төрөлд оролцсон тохиолдолд гаргана.
7. Тэмцээнтэй холбоотой асуудлыг лавлах утас 99308228, 99794599,

**Тэмцээн зохион байгуулах комисс**

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ ТОГТООМЖИЙГ СУРТАЛЧИЛАХ АЖЛЫН ХҮРЭЭНД  
 ЗОХИОН БАЙГУУЛАХ УИХ-ЫН ГИШҮҮН Н.ЭНХБОЛДЫН  
 НЭРЭМЖИТ “ АТАРЧИН-2017” СПОРТЫН НААДМЫН  
 ТӨСӨВ ЗАРДАЛ

2017-10-05

Зуунмод

№	Юунд зарцуулах	1-р байр	2-р байр	3-р байр	Бүгд дүн
1	Волейбол /эр 7, эм 7 /	14 x 25.000 = 350.000	14 x 20.000 = 280.000	14 x 15.000 = 210.000	840.000
2	Ширээний теннис /эр1, эм 1/	2 x 25.000 = 50.000	2 x 20.000 = 40.000	2 x 15.000 = 30.000	120.000
3	Шатар /эр1, эм 1/	2 x 25.000 = 50.000	2 x 20.000 = 40.000	2 x 15.000 = 30.000	120.000
4	Шагайн харваа /баг 7 хүнтэй/	7 x 25.000 = 175.000	7 x 20.000 = 140.000	7 x 15.000 = 105.000	420.000
5	Үндэсний бөх	100.000	80.000	2 x 50.000 = 100.00	280.000
6	Өргөмжлөл	Жаазтай 19 ш x 8.000 = 152.000 Жижиг 63 ш x 1500 = 94.500			246.500
7	Медаль	82 ш x 4.500			369.000
8	Анос				95.000
9	Багийн шагнал	350.000	300.000	250.000	900.000
10	Шүүгчдийн зардал	20 хүн x 2 хоног x 20.000			800.000
11	Шилдэг тамирчдын шагнал	Төрөл тус бүр 10 хүн x 30.000			300.000
	Нийлбэр дүн		4.490.500 төгрөг		

Арга зүйч

Төсөв хийсэн

Л.Хишигдэлгэр

БАТЛАВ.  
АЙМГИЙН БТС-ЫН ГАЗРЫН  
ДАРГА Га.ЛХАГВАСҮРЭН

**ТӨВ АЙМГИЙН БАГШ НАРЫН СПОРТЫН  
НААДМЫН УДИРДАМЖ**

2017.10.17

Зуунмод

**ЗОРИЛГО:**

- БАГШ НАРЫН СПОРЫН УР ЧАДВАРЫГ ДЭЭШЛҮҮЛЭХ , ХАРИЛЦАН ТУРШЛАГА СОЛИЛЦОХ , ИДЭВХ ТЭЙ ХӨДӨЛГӨӨН ЭРҮҮЛ МЭНД , СПОРТЫГ ХӨГЖҮҮЛЭХ, ТАМИРЧДАА ДЭМЖИХ НӨХӨРСӨГ ХАРИЛЦААГ БИЙ БОЛГОХОД ОРШИНО.

**ТЭМЦЭЭН ЯВАГДАХ ХУГАЦАА, ЗОХИОН БАЙГУУЛАЛТ:**

*Тэмцээн: 2017 оны 10 –р сарын 20-21-нд Төв аймгийн Угтаалцайдам суманд зохион байгуулагдана.*

**Тэмцээний төрөл:**

1. Волейбол	эрэгтэй -7 . эмэгтэй 7
2. Сагсан бөмбөг	эрэгтэй 6, эмэгтэй -6
3. Ширээний теннис	эрэгтэй -1 эмэгтэй – 1
4. Шатар	эрэгтэй -1 эмэгтэй – 1
5. Хөл бөмбөг	эрэгтэй -6 эмэгтэй 2

**Тэмцээний шаардлага:** Тухайн багш нар нийгмийн даатгалын дэвтэртэй байх

Аймгийн БТС-ын Газар

БАТЛАВ.  
АЙМГИЙН БТС-ЫН ГАЗРЫН  
ДАРГА Га.ЛХАГВАСҮРЭН

БАТЛАВ  
АХМАД БАГШ НАРЫН ХОЛБООНЫ  
ТЭРГҮҮН Г.ЧОГДОНХОРЛОО

АХМАД БАГШ НАРЫН ДУНД ЗОХИОГДОХ  
ТЭМЦЭЭНИЙ УДИРДАМЖ

2017-10-02

Зуунмод

**Нэг. Зорилго:**

Монголын багш нарын 51-н жилийн ойг тохиолдуулан ахмад багш нарын эрүүл мэндийг бэхжүүлэх, бие бялдрыг чийрэгжүүлэх, дасгал хөдөлгөөнийг амьдралын хэрэгцээ болгох, тэдний уялдаа холбоох сайжруулах, залуу үеийнхэнд сурталчилан таниулах зорилготой.

**Хоёр. Зохион байгуулах төрөл, хугацаа, бүрэлдэхүүн:**

Ахмад багш нарын дунд зохиогдох тэмцээнийг 2017 оны 10-р сарын 13-ны 10 цагаас Төв аймгийн БТС-ын газарт зохион байгуулагдана.

Тэмцээнийг Аймгийн БТС-ын Газраас томилогдсон шүүгчдийн бүрэлдэхүүн шүүн явуулна.

- |                       |            |
|-----------------------|------------|
| 1. Волейбол /холимог/ | эр 3, эм 3 |
| 2. Ширээний теннис    | эр 1, эм 1 |
| 3. 100-н буудалт даам | эр 1, эм 1 |

Тэмцээнд тухай сум, сургуульд ажиллаж байсан багш нарыг оролцуулна.

**Гурав. Шагнал урамшуулал**

Тэмцээнийг Аймгийн БТС-ын Газар, Ахмад багш нарын холбоо, Төв аймгийн 1-р 10-н жилийн сургуулийг 1983 8<sup>Г</sup>, анги, 1985 онд 10<sup>Г</sup> ангийг төгссөн төгсөгчид хамтран зохион байгуулан явуулна. .

Спортын төрөл тус бүрд эхний 3 байр эзэлсэн тамирчдыг медаль, өргөмжлөл, мөнгөн шагналаар шагнаж урамшуулна.

Аймгийн БТС-ын Газар, Ахмад багш нарын холбоо  
1983, 1985 оны төгсөгчид

БАТЛАВ.  
МХАХ-НЫ ЕРӨНХИЙ НАРИЙН БИЧГИЙН  
ДАРГА Ч.ЗОРИГТБААТАР

БАТЛАВ.  
АЙМГИЙН БТС-ЫН ГАЗРЫН  
ДАРГА Га.ЛХАГВАСҮРЭН

**ХҮҮХДИЙН ОЛОН ТӨРӨЛТИЙН УЛСЫН АВАРГА  
ШАЛГАРУУЛАХ ТЭМЦЭЭНИЙ ЕРӨНХИЙ ЗААВАР.**

2017-09-20

Зуунмод

**Хэзээ хаана болох:** 2017 оны 09 дүгээр сарын 29-нд Төв аймаг

**Зохион байгуулагч:** Монголын Хөнгөн атлетикийн холбоо Төв аймагт Биеийн Тамир, Спортын Газар

**Насны ангилал:** 14-15 нас 2003-2002 онд төрсөн

**Тэмцээний зай төрөл:** 60м, Уртын харайлт, 600м, Бөөрөнцөг 2 гараар урагш шидэх

**Тавигдах шаардлага:** Тэмцээнд Оролцогчидод энгэрийн номер олгоно. Тэмцээний хураамж 10.000 төгрөг. Оролцогч бүр сурагчийн хувийн хэрэг, төрсний гэрчилгээ ба иргэний үнэмлэх, 2 хувь зурагтай ирнэ.

**Шагнал:** Нийлбэр дүнгээр эхний 3 байрт орсон тамирчид, дасгалжуулагчдыг медаль, өргөмжлөл, мөнгөн шагналаар шагнана.

**Мандат олгох:** Тамирчдын мандатыг 2017-09-28-ны өдрийн 10-16 цагийн хооронд Төв аймаг Биеийн тамир спортын газар

**Техникийн зөвлөгөөн:** Тэмцээний техникийн зөвлөгөөнийг 2017-09-28-ны өдрийн 18 цагт Төв аймаг Биеийн тамир спортын газар

**Мэдүүлэг:** Тамирчдын мэдүүлгийг 2017 оны 09 дүгээр сарын 28-ны 16 цаг хүртэл Төв аймаг Биеийн тамир спортын газар илгээнэ. МХАХ-оос гаргасан “Мэдүүлгийн хуудас” дагуу үнэн зөв бөглөнө.

**Холбоо барих утас:** Л.Хишигдэлгэр 88222479

Аймгийн БТС-ын Газар

ДАРХАН АВАРГА Ж.МӨНХБАТЫН НЭРЭМЖИТ 2017 ОНЫ  
ӨСВӨР ҮЕИЙН АЙМГИЙН АВАРГА ШАЛГАРУУЛАХ  
ҮНДЭСНИЙ БӨХИЙН ТЭМЦЭЭНИЙ ЗААВАР.

2017-09-18

Зуунмод

**Нэг. Ерөнхий зүйл:**

1. Өсвөр үеийн аймгийн аварга шалгаруулах үндэсний бөхийн барилдаан 2017 оны 09-р сарын 21-22-ны өдрүүдэд Төв аймгийн Зуунмод суманд болно.
2. Барилдааныг 16, 17, 18 насны ангилалаар зохион байгуулах бөгөөд зөвхөн 16 нас хүрч, иргэний цахим үнэмлэх авсан хөвгүүд оролцоно
3. Иргэний цахим үнэмлэхээс өөр төрлийн бичиг баримт, тухайлбал “Е” серийн гадаад паспорт, ИБМТ-ийн зурагт лавлагаагаар бүртгэхгүй.
4. Тэмцээний 16 насны ангилалд 2000.10.01-нээс 2001-10-01-ний хооронд төрсөн хөвгүүд, 17 насны ангилалд 1999-10-01-нээс 2000-10-01-ний хооронд төрсөн хөвгүүд 18 насны ангилалд 1998-10-01-нээс 1999-10-01-ний хооронд төрсөн хөвгүүд тус тус оролцоно.
5. 27 сум, 31 сургуулиас шалгарсан нас тус бүрд 2 бөх оролцоно.
6. Бөхчүүд заавал иргэний үнэмлэхтэй байх ба албан ёсны зурагтай мэдүүлэг 1 % цээж зураг, эрхийн төлбөр 2500 төгрөгийг авч ирнэ.
7. Бөхчүүдийг 2017 оны 09-р сарын 21-ны өдөр 9<sup>00</sup> – 13<sup>00</sup> цагийн хооронд бүртгэж мандат олгон техникийн зөвлөгөөнийг 13<sup>00</sup> цагт хийнэ. Тэмцээн 2017 оны 09-р сарын 21-ны өдрийн 14<sup>00</sup> цагаас эхэлнэ.

**Хоёр. Барилдаан зохион явуулах аргачлал:**

1. Аймгийн аварга шалгаруулах тэмцээнийг тойргийн журмаар явуулна.Тодруулбал сумдаас шалгарсан бөхчүүд нас тус бүрдээ тойргоор барилдаж дүнг гаргана.
2. Багийн дүнг гаргахдаа бага онооны системийг хэрэглэнэ. Энэ нь нас тус бүрт барилдсан 6 бөхийн эзэлсэн байрын нийлбэр хамгийн бага байхыг гол үзүүлэлт болгох систем юм.Хэрэв энэ үзүүлэлт ижил гарвал дараах үзүүлэлтүүдийг ээлж дараалан харгалзах журмаар зохих байрыг тодруулна.

Үүнд:

- Гурван бөхийн давааны оноо
- Эзэлсэн байрын чанар
- Хамгийн бага насанд эзэлсэн байрыг тус тус харгалзана.

Харин аль нэг насанд бөх оролцуулаагүй бол тэр багт /насанд нь / хамгийн их оноог өгч байрыг эзэлүүлнэ.

Жич: Тэмцээнд оролцох байр, хоол, унааны зардлыг тухайн байгууллага өөрсдөө хариуцана.

Холбоо барих утас: 80015858 дасгалжуулагч Л.Энхбаяр

**Аймгийн БТС-ын газар**



БАТЛАВ  
АЙМГИЙН БТС-ЫН ГАЗРЫН  
ДАРГА Га.ЛХАГВАСҮРЭН

АЖ АХУЙН НЭГЖ, БАЙГУУЛЛАГЫН ДУНД ЗОХИОН  
ЯВУУЛАХ “ДУГУЙН АЯЛАЛ-2017” ӨДӨРЛӨГИЙН  
УДИРДАМЖ

2017-09-15

Зуунмод

**Нэг.Өдөрлөгийн зорилго**

Төр засгаас нийтийн биеийн тамир спортыг хөгжүүлэх талаар гаргасан бодлого шийдвэрийг хэрэгжүүлэх, дугуйн спортыг сурталчилах, дугуйгаар хичээллэх иргэл, хүүхэд залуучуудын хүрээг нэмэгдүүлэх, бие бялдрын өв тэгш хүмүүжил олгож эрүүл аж төрөх ёсыг төлөвшүүлэхэд оршино.

**Хоёр. Хаана болох, хугацаа**

“Дугуйн аялал - 2017” өдөрлөг нь 2017 оны 09-р сарын 23-ны 10<sup>00</sup> цагаас Мөнх алдарын талбайгаас гарч Овооны энгэр хүртэлх замд явагдана. Дугуйн өдөрлөгт БТС-ын Газарт хичээллэж буй дугуйн секцийн тамирчид, Спортын холбоод, албан байгууллага аж ахуйн нэгжүүдээс 3 ба түүнээс дээш хүн, дугуйн сонирхогч иргэд оролцоно.

**Гурав. Тэмцээний төрөл.**

Дугуйн аялалд оролцож буй иргэдийн дунд 2 км тойрогт бартаат замын буухиа уралдаан, граунд гольфийн тэмцээнүүдийг зохион байгуулна.

Аялалд оролцох байгууллагууд 20.000 төгрөгний эрхийн төлбөрийг төлж уралдаан тэмцээнд оролцоно. Эрхийн төлбөрөөр тэмцээний шагналын санг бүрдүүлнэ.

Дугуйн аялалын техникийн зөвлөгөөнийг 2017 оны 09-р сарын 22-ны өдрийн 15<sup>00</sup> цагаас Аймгийн БТС-ын Газрын хурлын танхимд хийнэ.

Жич.: Уралдах дугуйн, тормос, бусад эд ангиуд бүрэн байх, хамгаалалтын малгай, бээлийтэй байх шаардлагтай.

Аялалыг Аймгийн БТС-ын Газар, Цагдаагийн Газрын замын цагдаагийн тасаг, ЭМГазрууд хамтран зохион байгуулна.

Холбоо барих утас: 94060566 Дасгалжуулагч Г.Батсүх

**Аймгийн БТС-ын Газар**

БАТЛАВ.  
АЙМГИЙН БТС-ЫН ГАЗРЫН  
ДАРГА Га.ЛХАГВАСҮРЭН

АЖ АХУЙН НЭГЖ БАЙГУУЛЛАГУУДЫН АЖИЛТАН АЛБАН ХААГЧДЫН ДУНД  
ЗОХИОГДОХ “АЛТАН НАМАР -2017 ” БҮХ НИЙТИЙН ӨДӨРЛӨГИЙН  
УДИРДАМЖ

2017-09-18

Зуунмод

**Нэг.Өдөрлөгийн зорилго**

Зуунмод сумын нутаг дэвсгэр дээр үйл ажиллагаагаа явуулж байгаа албан байгууллага, аж ахуйн нэгжийн дунд нийтийн биеийн тамирыг хөгжүүлэх, чөлөөт цагийг зөв боловсон өнгөрүүлэх, хөдөлгөөний дутагдлаас урьдчилан сэргийлэх, төрийн болон төрийн бус байгууллага хоорондын холбоо, хамтын ажиллагааг сайжруулах, үйл ажиллагааг нийтэд сурталчилан таниулахад оршино.

**Хоёр. Өдөрлөгийг зохион байгуулах хугацаа, бүрэлдэхүүн:**

Албан байгууллага аж ахуйн нэгжүүдийн ажилчин албан хаагчдын дунд зохиогдох “Алтан намар-2017” өдөрлөг 2017 оны 9 сарын 30–ны өдрийн 11<sup>00</sup> цагаас Номтын аманд болно.

Өдөрлөгийн ерөнхий зохион байгуулагч: БТСГазар,

Хамтран зохион байгуулагч: ЭМГазар, АНЭ

Мэдээллийн ерөнхий ивээн тэтгэгч: ТBS телевиз, “Төв” телевиз

**Гурав. Өдөрлөгийн үеэр зохион байгуулагдах уралдаан тэмцээн**

2017 оны 09-р сарын 30-ны өдрийн 11<sup>00</sup> цагт оролцогч багууд өдөрлөгийн нээлтийн ажиллагаанд бэлэн жагссан байна.

Өдөрлөгт:

- 1.Граунд гольф эм 2, эр 2 хүн
2. Олс таталт эм 3, эр 3 хүн
3. Буухиа эм 3, эр 4 хүн оролцоно Буухиа тэмцээн: 1. Эр 500 м, 2. Эм 300 м, 3. Эр 800 м, 4. Эм 500 м, 5. Эр 1000 м, 6.Эм 800 м, 7. Эр: сүүлийн тамирчин дугуйтай 1 км замыг туулж барианд орно.

**Дөрөв.Шагнал урамшуулал**

Байгууллагын дүнг тэмцээн уралдаанд оролцсон байрны нийлбэрээр, төрөл тус бүрт амжилттай оролцсон багийгөргөмжлөл мөнгөн шагналаар шагнаж урамшуулна.

Жич: Байгууллага тус бүр өөрийн байгууллагын хаяг, эмблем, асар майхан барих, 1 дугуй бэлтгэх //Дугуйн хамгаалалтын малгай, бээлийтэй байна/

1. Байгууллага аж ахуйн нэгжүүд үдийн цай, хоол хүнсээ өөрсдөө бэлтгэх.
2. Тэмцээн уралдаанууд зэрэг явагдах тул 1 хүн 2 төрөлд давхардаж оролцож болохгүй тул байгууллагууд хүнээ эртнээс хувиарлах шаардлагатай
3. Байгууллага ажилчдын дунд нийтийн биеийн тамирын уралдаан зохион явуулах
4. Өдөрлөгийн дараа орчны хог хаягдлыг цэвэрлэх, байгаль орчноо хамгаалахад анхаарна.

Холбоо барих утас: 89960810 Арга зүйч Б.Золжаргал

“АЛТАН НАМАР” АХМАДУУДЫН ДУНД ЗОХИОН ЯВУУЛАХ  
ӨДӨРЛӨГИЙН УДИРДАМЖ

2017-09-11

Зуунмод

**Нэг.Өдөрлөгийн зорилго**

Зуунмод сумын 6-н багийн ахмадын дунд нийтийн биеийн тамирыг хөгжүүлэх, чөлөөт цагийг зөв боловсон өнгөрүүлэх, хөдөлгөөний дутагдлаас урьдчилан сэргийлэх, багуудын ахмадуудын хамтын ажиллагааг сайжруулах, үйл ажиллагааг нийтэд сурталчилан таниулахад оршино.

**Хоёр. Хаана болох, хугацаа**

Ахмадуудын дунд зохион явуулах “Алтан намар” өдөрлөгийг 2017 оны 09-р сарын 23-ны өдөр Төв цэнгэлдэх хүрээлэнд зохион байгуулна.

Ахмадын өдөрлөгийг Аймгийн БТСГазар, Аймгийн ахмадын хороо хамтран зохион явуулна

**Гурав.Тэмцээний төрөл.**

2017 оны 09-р сарын 23-ны өдрийн 10.00 цагт өдөрлөгт оролцогч багууд өдөрлөгийн нээлтийн ажиллагаанд бэлэн жагссан байна.

Өдөрлөгийн үеэр

1. Граунд гольфийн тэмцээн /Баг тус бүрээс Эр 2, Эм 2 тамирчин/
2. Софт волейболын тэмцээн /Баг тус бүрээс Эр 2, Эм 2 тамирчин/
3. Хийн дасгалын тэмцээн / 10-аас дээш хүний бүрэлдэхүүнтэй байна/ эдгээр тэмцээнүүдийг зохион явуулна.

**Дөрөв.Шагнал урамшуулал**

Тэмцээний төрөл тус бүрт эхний 3 байрт шалгарсан багт алт, мөнгө, хүрэл медаль, өргөмжлөл, мөнгөн шагналаар шагнаж урамшуулна.

Аймгийн БТС-ын Газар

БАТЛАВ.  
НИЙГМИЙН БОДЛОГЫН ХЭЛТСИЙН  
ДАРГА Д.МӨНХЦЭЦЭГ

ТӨВ АЙМГИЙН ЗҮҮН БҮСИЙН СУМДЫН АХМАДУУДЫН  
“ХӨДӨЛГӨӨН ЭРҮҮЛ МЭНД “ ӨДӨРЛӨГИЙН УДИРДАМЖ

2017-08-15

Зуунмод

Нэг. Зорилго:

Ахмад настнуудын эрүүл мэндийг бэхжүүлэх, хүн амын бие бялдрыг чийрэгжүүлэх, дасгал хөдөлгөөнийг амьдралын хэрэгцээ болгох, хөдөлгөөний хомсдлоос сэргийлэх, эрчимжүүлэх, тэдний спортын амжилтыг ахиулах зорилготой.

Хоёр. Өдөрлөгийг зохион байгуулах хугацаа, бүрэлдэхүүн:

2017 оны 8 – р сарын 26-ны 10 цагаас Мөнгөнморьт суманд зохион байгуулагдана,Зүүн бүсийн сумд /Архуст, Баяндэлгэр, Баянжаргалан, Баян, Эрдэнэ, Мөнгөнморьт, Сэргэлэн/ - ын спорт сонирхогч ахмад тамирчдаа бэлтгэн оролцуулна.

Гурав. Хамтран ажиллах байгууллага:

Өдөрлөгийг Мөнгөнморьт сумын ЗДТГ,Аймгийн БТС-ын Газар, Ахмадын хороотой хамтран зохион байгуулана.

Дөрөв.Тэмцээнүүд, оролцох тамирчдын тоо, насны ангилал

1. Хөгжилтэй буухиа 45-дээш нас эр 2, эм 2
2. Софт волейбол 50-аас дээш нас эр 2, эм 2
3. Гранд гольф 50-аас дээш нас эр 2, эм 2

Сумдаас тэмцээнд оролцох тамирчдын иргэний үнэмлэх, оролцох төрлийн мэдүүлэгийг бэлтгэж ирнэ.Тамирчин зөвхөн 1 төрөлд оролцоно.

Тав. Дүгнэх журам

Тэмцээнийг Аймгийн БТСГ, Ахмадын хороо, Мөнгөнморьт сумын ЗДТГ-аас томилогдсон комисс, шүүгч нар удирдан шүүж явуулна.Тэмцээний дүнг төрөл бүрээр хувийн дүнг гаргаж, багийн дүнг төрөлд бүр орсон амжилтаар гаргана.

Зургаа.Шагнал урамшуулал

Спортын төрөл тус бүрээр хувийн дүнг гаргаж эхний 3 байр эзэлсэн тамирчдыг медаль, өргөмжлөлөөр шагнана.Багийн дүнгээр I байранд орсон багийг цом, медаль,өргөмжлөл,мөнгөн шагнал, II,III байрыг медаль,өргөмжлөл,мөнгөн шагналаар шагнана .

Тайлбар:Сумдад урлагын 1-2 үзүүлбэр бэлтгэж ирнэ.

1. Бүсийн сумдын ахмадын хороодын туршлага солилцох зөвлөгөөн семинар хийх /Ахмадын хороо /
2. Мөнгөнморьт суманд аялалын маршрут тогтоох / БТСГ/
- 3.НБТ-ийн чиглэлээр зохион байгуулсан үйл ажиллагаатай танилцах,арга зүйн зөвөлгөө өгөх /БТСГ/

Аймгийн БТС-ын Газар, Ахмадын хороо

БАТЛАВ.  
ЭРҮҮЛ МЭНДИЙН ГАЗРЫН  
ДАРГА С.МӨНХТУЯА

БАТЛАВ.  
АЙМГИЙН БТС-ЫН ГАЗРЫН  
ДАРГА Га.ЛХАГВАСҮРЭН

АЛХАЛТ, ГҮЙЛТ, ДУГУЙ ЗАМ МАРШРУТЫН СУДАЛГААНЫ БАГ  
СУМДАД АЖИЛЛАХ УДИРДАМЖ

2017-08-15

Зуунмод

Нэг. Зорилго:

Монгол улсын Ерөнхийлөгчийн нэрэмжит сорилын аяны хүрээнд Засгийнгазрын 05-р тогтоолыг хэрэгжүүлэх, иргэдийн эрүүл мэнд, бие бялдрын боловсролыг дээшлүүлэх, биеийн тамираар хичээллэгчдийн идэвхи санаачлагыг дэмжих, сум, аж ахуйн нэгж, байгууллагын хамтын ажиллагааг өргөжүүлэхэд тэмцээний зорилго оршино.

Хоёр. Сорилын багийн ажиллах сумд, хугацаа, бүрэлдэхүүн:

Мөнгөнморьт суманд 2017 оны 08-р сарын 26 ний өдрүүдэд ажиллана.

Багийн бүрэлдэхүүнд:

- |                   |                          |
|-------------------|--------------------------|
| 1. Га.Лхагвасүрэн | БТС-ын Газрын дарга      |
| 2. Б.Золжаргал    | БТСГ-ын НБТ-ын арга зүйч |
| 3. Н.Ариунтуул    | ЭМГ-ын НБТ-ын арга зүйч  |

Гурав. Хамтран ажиллах байгууллага:

БТС-ын Газар, ЭМГазар, сумдын ЗДТГазар, НБТ-спортын хамтлаг, НБТ-спорт хариуцсан мэргэжилтэн, сургуулийн БТ-ын багш нар

Дөрөв. Ажлын чиг үүрэг

1. Сумдын ББХЧ-ийн сорил судалгааг хариуцсан ажилтанд арга зүйн зөвлөгөө өгөх.
2. Сумдын НБТ-спортын чиглэлээр зохион байгуулсан ажилтай танилцах, арга зүйн зөвлөгөө өгөх
3. Ажлын байранд хийх, ЕБС-ийн завсарлагааны дасгал, хийн дасгалыг тогтмолжуулсан байдал
4. Алхалт, гүйлтийн маршруттай танилцах

Тав. Тайлан мэдээг тайлагнах

Мөнгөнморьт сумнд ажилласан тухай тайлан мэдээг ажлын 3 хоногийн дотор багтаан тайлагнах, үр дүнг тооцох.

Аймгийн БТС-ын Газар

**ГРАУНД ГОЛЬФИЙН ОЛОН УЛСЫН  
ТЭМЦЭЭНИЙ ЗААВАР.**

**Нэг. Зорилго:**

Монголын ахмад тамирчид, мастеруудын эрүүл мэнд, биеийн тамир чийрэгжүүлэлтийг дэмжих, чөлөөт цагийг зөв өнгөрүүлэх, шинээр хөгжиж буй граунд гольфийн спортын өөрийн эх орондоо төдийгүй, хөрш зэргэлдээ орнууддаа сурталчилан эрчимтэй хөгжүүлэх, энэхүү спортоор хичээллэж буй мастеруудын ур чадварыг улам дээшлүүлэх, тэдний спортын амжилтыг ахиулах, тамирчид харилцан туршлага солилцох, шилдэг тамирчинг шалгаруулахад тэмцээний гол зорилго оршино.

**Хоёр. Тэмцээний зохион байгуулалт**

Граунд гольфийн олон улсын тэмцээнийг Монголын мастеруудын биеийн тамир, спортын холбоо, Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Биеийн Тамир Спортын Газар, Монголын Үндэсний Граунд гольфийн холбоо, Төв аймгийн ЗДТГ, БТС-ын Газар хамтран зохион байгуулна.

**Гурав. Тэмцээн явагдах газар, хугацаа, журам:**

Тэмцээн Төв аймгийн Зуунмод хотод 2017 оны 08-р сарын 19-20-ны өдрүүдэд явагдана. Тэмцээнд Монгол улс, ОХУ, Польш, Испани, Энэтхэг, Канад, БНСУ, Япон, Вьетнам улсын баг тамирчид оролцоно.

**Дөрөв. Техникийн зөвлөгөөн, бүрдүүлэх материал:**

Тэмцээний техникийн зөвлөгөөнийг 2017 оны 08 дугаар сарын 14-ны өдрийн 1100 цагт Спортын төв ордны хурлын танхимд хийнэ. Багийн ахлагч, тамирчид дараах бичиг баримтыг албан ёсоор бүрдүүлж 2017 оны 05-р сарын 11-ны өдрөөс өмнө ММБТСХ-д ирүүлнэ Үүнд:

1. Тэмцээнд оролцохыг зөвшөөрсэн эмнэлгийн магадлагаа
2. Иргэний үнэмлэх
3. 2 % цээж зураг /4x6/, бичиг баримтыг үндэслэн мандат олгоно.

**Тав. Шагнал урамшил**

Тэмцээнд амжилттай оролцож эхний 3 байранд шалгарсан баг тамирчдыг медаль, өргөмжлөл, мөнгөн шагналаар шагнана.

Мөн тэмцээний үеэр 1 /нэг/ удаагийн цохилтоор бөмбөгийг үүрэнд оруулсан тамирчдад тусгай шагнал гардуулна.

БАТЛАВ.  
АЙМГИЙН БТС-ЫН ГАЗРЫН  
ДАРГА Га.ЛХАГВАСҮРЭН

\*ТҮМЭН АЧЛАЛ\* ТББ-ЫН НЭРЭМЖИТ “MASTER-CUP”-2017 КРОСС  
УРАЛДААНЫ АЙМГИЙН АВАРГА ШАЛГАРУУЛАХ ТЭМЦЭЭНИЙ ЗААВАР.

2017-08-17

Зуунмод

**Нэг. Зорилго:**

Хөнгөн атлетикийн спортыг хөгжүүлэх гүйлтийн төрлөөр хичээллэх хүүхэд залуучуудыг өргөнөөр хамруулах, тэдний бие бялдрыг чийрэгжүүлэх, өсвөрийн шигшээ багийн тамирчдыг сонгон шалгаруулах, спортын амжилтыг нь ахиулах, Кросс уралдааны УАШТ-нд оролцох баг тамирчдыг сонгон шалгаруулахад оршино.

**Хоёр. Тэмцээний хугацаа, зохион байгуулах газар**

Тэмцээн 2017 оын 09-р сарын 09-ны өдөр Төв аймаг Зуунмод суманд болно.Тэмцээнийг Аймгийн БТС-ын Газар, \*Түмэн ачлал\* ТББ хамтран зохион байгуулан явуулна.

**Гурав. Тэмцээний төрөл зай, оролцох хүний тоо:**

Тэмцээнийг 5-н насны ангилалаар зохион явуулна.

1. 8-9 насанд Охид 1, Хөвгүүд 1- 800 м
2. 10 -11 насанд Охид 1, Хөвгүүд 1- 1200 м
3. 12-13насанд Охид 2 м, Хөвгүүд 2- 1500 м
4. 14-15насанд Охид 1 м, Хөвгүүд 1- 3000 м
5. 16-17насанд Охид 1 м, Хөвгүүд 1- 4000 м

**Дөрөв. Тэмцээний шагнал урамшил:**

Тэмцээний зай тус бүрт 1-3-р байр эзэлсэн тамирчдад алт, мөнгө, хүрэл медаль, өргөмжлөл, үнэ бүхий зүйлээр шагнаж урамшуулна.

Багийн нэгдсэн дүнгээр 1-р байр эзэлсэн багийг цом, өргөмжлөл, мөнгөн шагнал 2-5-р байр эзэлсэн багийг өргөмжлөл мөнгөн шагналаар шагнаана.

Багийн дүнг гаргахдаа 12 тамирчны үзүүлсэн амжилтын нийлбэрээр гаргана.

Жич: 1. Тэмцээн 2017 оны 09-р сарын 09-ны 11.00 цагт эхэлнэ.

2. Тэмцээнд баг тамирчдаа оролцуулж буй байгууллага, аж ахуйн нэгжүүд байр, хоол, унааны зардлаа өөрсдөө хариуцана.

Тэмцээнд оролцох тамирчид холбогдох бичиг баримтаа зааврын дагуу бүрдүүлж ирнэ.

1. Хувийн хэрэг
2. Иргэний үнэмлэх
3. Төрсний гэрчилгээ
4. ЭМД –ын дэвтэр
5. 2 % цээж зураг
6. Эрхийн төлбөр 2500 төгрөг
7. Тамирчид тусгай номер олгоно

Холбоо барих утас: 99308228

Аймгийн БТС-ын Газар

БАТЛАВ.  
АЙМГИЙН БТС-ЫН ГАЗРЫН  
ДАРГА Га.ЛХАГВАСҮРЭН

2017-ОНЫ АЙМГИЙН АВАРГА ШАЛГАРУУЛАХ  
МАСТЕР СУР ТЭМЦЭЭНД ШААРДАГДАХ ЗАРДЛЫН ТӨСӨВ

2017-08-16

Зуунмод

№	Төсвийн зарцуулалт	Хүний тоо	Нэгхүндноогдохшагнал	Олговол зохих
1	Медаль	33	Медаль 33 х 3500=115.500	115.500
2	Өргөмжлөл	53	Жижиг 50 х 1000 = 50.000 Том 3 х 5000 = 15.000	65.000
3	Цом	1	30.000	30.000
	Нийлбэр дүн			210.500

Хийсэн арга зүйч

Л.Хишигдэлгэр

Төсөв

Хянасан ня-бо

Д.Батдулам



2017 ОНЫ АЙМГИЙН АВАРГА ШАЛГАРУУЛАХ ЦЭЦЭРЛЭГИЙН  
УРАН ХӨДӨЛГӨӨНТ ГИМНАСТИКИЙН ТЭМЦЭЭНИЙ ЗААВАР

2017-05-09

Зуунмод

**Нэг.Тэмцээний зорилго**

Хүүхдийн бие бялдрыг зөв хөгжүүлэх,хөдөлгөөний эвслийг сайжруулах дасгал хөдөлгөөнийг амьдралын хэрэгцээ болон төлөвшүүлэх,уран хөдөлгөөнт гимнастикийг нийтийн хүртээл болгон сурталчилахад оршино.

**Хоёр.Тэмцээний зохион байгуулалт,явагдах хугацаа**

Тэмцээнийг 2017 оны 05- р сарын 27 – ны өдөр Аймгийн БТСГазрын спорт цогцолборт зохион явуулна.Уран хөдөлгөөнт гимнастикийн тоглолтонд эм 6, эр 6 байна.Нэг байгууллагаас хэдэн ч баг оролцож болно.

**Гурав.Тэмцээний журам**

Уран хөдөлгөөнт гимнастик заавал хийх дасгал, хувийн хөтөлбөрт дасгалаас бүрдэнэ.Хувийн хөтөлбөрт дасгал нь цэцэрлэгийн хүүхдийн насны онцлогт тохирсон бие бялдрыг хөгжүүлэх гимнастикийн үндсэн дасгалуудаас бүрдсэн байх шаардлагатай.Заавал хийх дасгалын хугацаа 2,15 минут зохиомж 2,00 минут нийт 4,15 минут байна.Тоглолтыг зохиомж хувцаслалт, дасгалын сонголт, хугацааг нарийн баримтлан, хөгжмийн бичлэгийг шаардлага хангасан байлгах шаардлагатай.Заавал хийх дасгал нь 2017 онд тараагдсан дасгалаар хийгдэнэ.

**Дөрөв.Техникийн зөвөлгөөн мандат олгох журам**

2017 оны 05 – р сарын 26 –ны өдрийн 15.00 – 17.00 цагт мандат олгож 18.00 цагт техникийн зөвөлгөөнийг Аймгийн БТСГ-ны сургалтын танхимд хийнэ.Багуудын бүрдүүлэх зүйл :

- 1.Төрсний гэрчилгээ
- 2.Эрүүл мэндийн дэвтэр
- 3.2 % цээж зураг /3\*4 /
- 4.Эрхийн төлбөр 2500

Жич:Тэмцээнд оролцож байгаа баг тамирчдын байр,хоол унааны зардлыг тухайн байгууллага хариуцна.

**Тав.Шагнал урамшил**

Тэмцээний эхний 3 байр эзэлсэн баг тамирчдыг алт,мөнгө,хүрэл медаль, өргөмжлөл,мөнгөн шагналаар шагнаж урамшуулна.

**БАТЛАВ**  
**АЙМГИЙН БТС-ЫН ГАЗРЫН**  
**ДАРГА** **Га.ЛХАГВАСҮРЭН**

**БАТЛАВ**  
**ҮЙЛДВЭРЧНИЙ ЭВЛЭЛИЙН**  
**ХОЛБООНЫ ДАРГА** **Д.ОЮУН**

**БАТЛАВ. АЙМГИЙН ВОЛЕЙБОЛЫН**  
**ХОЛБООНЫ ТЭРГҮҮН** **Д.БААТАР**

## **ТӨВ АЙМГИЙН ҮЙЛДВЭРЧНИЙ ЭВЛЭЛИЙН ХОЛБООНЫ НЭРЭМЖИТ ЦОМЫН ТӨЛӨӨХ ВОЛЕЙБОЛЫН ТЭМЦЭЭНИЙ ЗААВАР**

2017.04.14

Зуунмод хот

### **Нэг. Зорилго:**

Волейболын спортоор хичээллэгчдийн хүрээг нэмэгдүүлэх, шинэ залуу болон шилдэг тамирчдыг алдаршуулах, тамирчдын ур чадварыг дээшлүүлэх, үйлдвэрчний эвлэлийн гишүүд , дэмжигчдийн идэвхийг өрнүүлэх , харилцан туршлага солилцоход оршино.

### **Хоёр. Тэмцээний зохион байгуулалт , явуулах хугацаа:**

Тэмцээн 2017 оны 04-р сарын 29,30-ны өдрүүдэд Төв аймгийн Спортын ордонд болно. Төв аймгийн БТСГазар, Аймгийн Үйлдвэрчний Эвлэлийн Холбоо, Аймгийн Волейболын холбоо хамтран зохион байгуулна.

### **Гурав. Спортын төрөл ,багийн бүрэлдэхүүн :**

Тэмцээнд сумын ҮЭ-ийн холбооны дарга, Аж ахуйн нэгж байгууллагын ҮЭ-ийн хорооны дарга нар багаа ахлаж оролцоно, баг тус бүр 8 хүний бүрэлдэхүүнтэй байна. 19-35 насны 4 тоглогч, 36 дээш насны 4 тоглогч байна. Тухайн насны тоглогчийг тухайн насны тоглогчоор солилцоо хийнэ. Техникийн зөвлөгөөн 2016 оны 04 сарын 28-ны өдрийн 18,00 цагаас аймгийн Спорт ордонд болно.

### **Дөрөв. Тэмцээний ангилал :**

1. Иргэний үнэмлэхтэй ирнэ./ Иргэний үнэмлэх байхгүй бол лавлагаа авч ирнэ. Бичиг баримтын зөрчилтэй бол тэмцээнд оролцуулахгүй./
2. Лигийн тамирчид оролцохгүй.
3. Аймаг сумын харъяалалтай байна.
4. Ерөнхий боловсролын сургуулийн сурагчид оролцохгүй.

### **Тав. Шагнал урамшуулал :**

Тэмцээний 1,2,3-р байр эзэлсэн тамирчдыг алт, мөнгө, хүрэл медаль, өргөмжлөл мөнгөн шагналаар шагнаж урамшуулна. Түрүүлсэн багт Аймгийн ҮЭ-ийн Холбооны нэрэмжит “Шилжин явах цом” гардуулна. Шилдэг эрэгтэй 1, эмэгтэй 1 тамирчдыг тодруулан өргөмжлөл, мөнгөн шагналаар шагнаж урамшуулна.

### **Зургаа. Төсөв зардал :**

Тэмцээнд оролцох сум, аж ахуйн нэгж , байгууллагын тамирчдын байр , хоол , унааны зардлыг тухайн байгууллага хариуцна.

**ТЭМЦЭЭНИЙГ ЗОХИОН БАЙГУУЛАХ КОМИСС**

БАТЛАВ  
АЙМГИЙН БТС-ЫН ГАЗРЫН  
ДАРГА Га.ЛХАГВАСҮРЭН

БАТЛАВ.  
ҮЙЛДВЭРЧНИЙ ЭВЛЭЛИЙН  
ХОЛБООНЫ ДАРГА

Д.ОЮУН

БАТЛАВ:АЙМГИЙН ВОЛЕЙБОЛЫН  
ХОЛБООНЫ ТЭРГҮҮН Д.БААТАР

**ТӨВ АЙМГИЙН ҮЙЛДВЭРЧНИЙ ЭВЛЭЛИЙН ХОЛБООНЫ  
НЭРЭМЖИТ ЦОМЫН ТӨЛӨӨХ ВОЛЕЙБОЛЫН ТЭМЦЭЭНИЙ  
ХӨТӨЛБӨР**

2017.04.14.

Зуунмод сум

**2017 оны 04-р сарын 28-нд**

18.00 цагаас баг тамирчдын тэмцээнд оролцох эрхийн төлбөр, сугалаа явуулах техникийн зөвлөгөөн болно. /Эрхийн төлбөр өгөөгүй багийг тэмцээнд орлуулахгүй/

**2017 оны 04-р сарын 29 -нд**

- 9.00 Волейболын тэмцээн Спортын ордонд
- 12.00 Волейболын тэмцээний нээлтийн ажиллагаа
- 12.30 Тэмцээний үргэлжлэл

**2017 оны 04-р сарын 30-нд**

- 9.00 Тэмцээний үргэлжлэл шигшээ тоглолтууд
- 15.00 Тэмцээний хаалтын ажиллагаа / Шагнал гардуулах /

**ТӨВ АЙМГИЙН БИЕЙН ТАМИР СПОРТЫН ГАЗАР.**

БАТЛАВ:  
